

**АЙМГИЙН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

2019.01.28

№ 03

Алтай хот

№	Хэлэлцэх асуудал	Хэн хэлэлцүүлэх	Хэн байлцах	Гарах шийдвэр
1	Ажлын хэсэг байгуулах тухай	Л.Батжаргал		Тогтоол 12
2	Буцалтгүй тусламж олгох тухай	А.Амарзаяа	Г.Соёлоо	Тогтоол 13

**ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
АЖЛЫН АЛБА**



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 13

Есөнбулаг сум

Буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Говь-Алтай аймгийн Цээл сумын уугуул, төр нийгмийн зүтгэлтэн Монгол Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд асан Цэдэвийн Дашдорж хүнд өвчний улмаас нас барсан тул буяны ажилд нь зориулан 1,000,000 /нэг сая/ төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Буцалтгүй тусламжийн 1,000,000 төгрөгийг ИТХ-ын бараа үйлчилгээний бусад зардлаас гаргахыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албаны нягтлан бодогч /Г.Соёлоо/-д даалгасугай.

ДАРГА  Л.БАТЖАРГАЛ



0000045



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 12

Есөнбулаг сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Говь-Алтай аймгийн Цээл сумын уугуул, төр нийгмийн зүтгэлтэн Монгол Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд асан Цэдэвийн Дашдорж хүнд өвчний улмаас нас барсан тул буяны ажил явдлыг зохион байгуулж ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Батжаргал- Аймгийн ИТХ-ын дарга

Гишүүдэд: А.Пүрэвсүрэн- Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч, Тэргүүлэгч

М.Дашпунцаг- Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч, Тэргүүлэгч

Ж.Амартүвшин- Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч, Тэргүүлэгч

Ч.Бат-Эрдэнэ- Аймгийн ЗДТГ-ын дарга

А.Амарзаяа- Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

М.Эрдэнэбилэг- Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

М.Мянганбуу- Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга

Д. Батбаяр -Аймгийн Нисэх буудлын дарга

В. Сүррагчаа -Аймгийн Төрийн банкны захирал

А.Цанжид - Цээл сумын Засаг дарга

Л.Алтангэрэл -Төгрөг сумын Засаг дарга

В.Рэнцэндорж- Аймгийн МАН-ын хорооны дарга

ДАРГА  Л.БАТЖАРГАЛ